

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН Ө.ХОСБАЯРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг.Нэгжийн мэдээлэл технологийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, шаардлагатай шинэчлэлт, сайжруулалтыг хийх, төлөвлөх							
1	Арга хэмжээ №1.1. Нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд мэдээллийн технологид хамаарах хэсгийг хэрэгжүүлж тайлагнах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	-	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, тайлагнасан байна.	Хавирга, Бичигт, Сүмбэр боомтуудад хяналтын камер нэвтрүүлж, сүлжээнээс хяналт тавихад бэлэн болгосон.	2024.09.16 2024.11.29	Тус шугаар
2	Арга хэмжээ №1.2. Гадаад иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, байгууллагын програм хангамж, мэдээллийн сан, нэгжийн мэдээлэл технологийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах	Хууль тогтоомжид нийцсэн байна.	-	Програм хангамж, мэдээллийн сан, мэдээллийн технологийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал хяналт тавьж ажилласан. Тус хугацаанд Бичигт, Баянхошуу, Эрэнцав боомтуудын интернэт сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан. Төв байрны 3 давхрын коридорт 5 камер, виз, зөвшөөрлийн газарт 7 камер, зөрчил шалган шийдвэрлэх газрын коридорт 1 камер, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн коридорт 1 камер, серверийн өрөөнд 1 камер, нийт 15 камерыг мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Э.Наранбат нарын хамт тус тус суурилуулж нэвтрүүлсэн.	2024.09.16 2024.11.29	90

1	2	3	4	5	6	7	8
					Боомт орон нутаг дахь газар, хэлтсүүдийн үйл ажиллагааг хянах, төв газрын хяналтын камерын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд 3үүн бүс дэх газрын гадна байрлах 4 камер, дотор байрлах 4 камеруудыг сүлжээнээс хянах боломжтой болгож, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Бат-Өлзийгийн компьютерт суулган бэлэн болгож, бүсийн газруудыг сүлжээнээс хянах дэлгэцийг суурилуулж холбогдох тохиргоог хийж ажилласан. Виз, зөвшөөрлийн газарт програм хангамж хариуцсан мэргэжилтэн Б.Одбаяр, мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Э.Наранбат нарын хамт интернэт сүлжээ болон дотоод сүлжээний аюулгүй байдал, тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үүднээс сүлжээний зохион байгуулалт хийж ажилласан. Баянхошуу боомтын хяналтын улсын байцаагч Б.Бат-Эрдэнэтэй хамтарч дотоод сүлжээг нэвтрүүлж Гэрэгэ систем ашиглахад бэлэн болгосон. Ерөнхий газрын хэмжээнд зохион байгуулагдсан 8 удаагийн сургалтыг зохион байгуулах техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцаж ажилласан.		
3	Арга хэмжээ №1.3. Мэдээллийн технологийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэ хэрэгцээ, шаардлагад тохируулах, хуучин програм хангамжийг засварлаж, сүлжээний схем зураглал гаргах,	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	-	Нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамж, сүлжээ, техник хангамж хоцрогдолд ороогүй, хэрэглэгчийн шаардлага хангасан,	Боомт орон нутаг дахь газар, хэлтсүүдийн үйл ажиллагааг хянах, төв газрын хяналтын камерын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд тус газар, хэлтсүүдээс шаардлагатай байгаа тоног, төхөөрөмжийн судалгаа авч, үр дүнг үнийн саналтай Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Э.Ганзоригт танилцуулсан. Ерөнхий газрын интернэт сүлжээ, дотоод сүлжээ, камерын сүлжээний топологи зургийг мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан,	2024.09.16 2024.11.29	90

147

1	2	3	4	5	6	7	8
	нэмэлт өөрчлөлт оруулах, удирдлагад танилцуулах			шинэчлэлт сайжруулалт хийгдсэн байна.	Э.Наранбат нарын хамт боловсруулж мэдээллийн технологийн хэлтсийн дарга Э.Ганзоригт танилцуулж, өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвчулуунд хүлээлгэн өгсөн.		
Хоёр. Мэдээлэл технологийн чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аюулгүй байдлын ослын үеийн арга хэмжээ, журам, зааврыг мөрдөж, мэдээллийн сангийн сервер, түүнд шаардлагатай програмуудыг суулгаж, сайжруулсан загвараар өөрчлөх							
4	Арга хэмжээ №2.1. Мэдээлэл, технологийн хууль, тогтоомж, стандарт, зааварчилгааг албан хаагчдад танилцуулж, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Хууль тогтоомжид нийцсэн байна.	-	Холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангах ажил хийгдсэн байна.	Байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа нийт албан хаагч нарт мэдээллийн аюулгүй байдал, интернэт сүлжээ, дотоод сүлжээ, систем, тоног төхөөрөмжтэй холбоотой 28 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.	2024.09.16 2024.11.29	90
5	Арга хэмжээ №2.2. Аюулгүйн арга хэмжээ, хөдөлмөр хамгааллын талаарх холбогдох зааврыг мөрдөх	Хууль тогтоомжид нийцсэн байна.	-	Хөдөлмөрийн хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байна.	Байгууллагын даргын А/17 тушаалаар баталсан "Аюулгүй ажиллагааны зааварчилгаа батлах тухай" тушаалын дагуу хөдөлмөрийн хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.	2024.09.16 2024.11.29	90
6	Арга хэмжээ №2.3. Мэдээллийн сангийн серверт шаардлагатай програмуудыг суулгах, тохиргоо хийж, зохион байгуулалт, бүтэц, дизайныг үүсгэх	Хууль тогтоомжид нийцсэн байна.	-	Мэдээллийн санд шаардлагатай тохиргоог хийж холбогдох арга хэмжээг авсан байна.	Cisco 2960 managed switch-ний update хийх, Terminal hostname тохируулах, Terminal hostname-ийн нууц үг тохируулах, SSH тохируулах, VLAN устгах, нэмэх, тохируулах, Port security MAC хаяг нэмэх, тохируулах зэрэг гарын авлагыг мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Э.Наранбат нарын хамт бэлтгэж, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Э.Ганзоригт танилцуулсан. Ерөнхий газрын интернэт сүлжээ болон дотоод сүлжээний MAC хаягийн бүртгэлийг шинэчилсэн.	2024.09.16 2024.11.29	80

148

1	2	3	4	5	6	7	8
					Баянхошуу, Бичигт боомтуудад "Transient card system" програмын алдааг засварлаж гадаадын иргэний хурууны хээг авахад бэлэн болгосон.		
7	Арга хэмжээ №2.4. Байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлж буй аливаа програмыг ашиглах аргад шуурхай суралцаж, албан хаагчдыг мэдээллээр хангах, ашиглах үйл явцад хяналт тавьж, дэмжих	Хууль тогтоомжид нийцсэн байна.		Холбогдох арга хэмжээг авсан байна.	Оршин суух үнэмлэх хэвлэлтийг автоматжуулах киоск машины төслийн товч танилцуулгыг програм хангамж хариуцсан мэргэжилтэн Б.Бадамринчин, мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Э.Наранбат нарын хамт хийж мэдээллийн технологийн хэлтсийн дарга Э.Ганзоригт танилцуулсан. Сүлжээ хариуцсан мэргэжилтэн Б.Уранчимэг, өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвчулуун нарын зөвлөгөөний дагуу "ISF" системийн цэсүүдийн програм хангамжийн хөгжүүлэлтийг хийсэн.	2024.09.16 2024.11.29	80
Гурав. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
8	Арга хэмжээ №3.1. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох	Оролцсон арга хэмжээний тоо		Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон байна.	Монгол Улсын Их Сургуулийн эрдмийн өргөөнд зохион байгуулагдсан "Дижитал нийтийн үйлчилгээ ба идэвх санаачилга" хэлэлцүүлэгт 10 дугаар сарын 17-ны өдөр оролцсон. Мобинет ХХК-аас зохион байгуулсан "Digital Enterprise" арга хэмжээнд 11 дүгээр сарын 01-ний өдөр мэдээллийн технологийн хэлтсийн дарга Э.Ганзориг, програм хангамж хариуцсан мэргэжилтэн Б.Одбаяр, мэдээллийн технологийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Э.Наранбат нарын хамт оролцсон. Улаанбаатар дахь Энэтхэгийн Элчин Сайдын Яам 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан "ITEC DAY-2024" арга хэмжээнд оролцсон.	2024.09.16 2024.11.29	90

1	2	3	4	5	6	7	8
					"Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслол журам"-ын дагуу 11 дүгээр сарын 22-ны өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.		
9	Арга хэмжээ №3.2. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх	Гүйцэтгэлийн хувь	-	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар цаг хугацаандаа биелсэн байна.	Баянхошуу боомтод суурилуулах шаардлагатай хяналтын камер худалдан авах талаар танд илтгэх хуудсаар танилцуулсан.	2024.09.16 2024.11.29	<i>Тус тусгай</i>

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1	Арга хэмжээ 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас "Төрийн албан хаагчийг сургах тогтолцоог сайжруулах" ажлын хүрээнд Удирдлагын Академийн багш нарын бэлтгэсэн төрийн албан хаагчдын судлах "Хүний эрх" сэдэвт анхан, дунд, ахисан түвшний 3 модультай 100% хувийн цахим сургалтыг бүрэн судлах	Суралцсан сэдэв, авсан сертификат ын тоо	-	Хүний эрхийн талаарх мэдлэг мэдээлэл дээшилсэн байна.	Удирдлагын академийн Төрийн албан хаагчдад зориулсан "Хүний эрх" 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад амжилттай суралцаж, цахим сертификат авсан.	2024.09.16 2024.11.29	50.

3	Арга хэмжээ 2. Шинээр томилогдсон албан хаагчийн чиглүүлэх сургалтад хамрагдах	Суралцсан сэдэв, авсан сертификат ын тоо	-	Шинээр томилогдсон албан хаагчийн чиглүүлэх сургалтад хамрагдаж батламж авсан байна.	Шинээр томилогдсон албан хаагчийн чиглүүлэх сургалтад 11 дүгээр сарын 18- ны өдрөөс 22-ны өдрүүдэд суралцаж, сургалтын үр дүнг үнэлэх шалгалтыг амжилттай өгч, батламж гардан авсан.	2024.09.16 2024.11.29	100
---	---	---	---	---	--	--------------------------	-----

ТАЙЛАН ГАРГАСАН:
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ө.ХОСБАЯР

2024 оны 12 дугаар сарын ...

137